

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.9.1	Мөнгөн хөрөнгө	7
2.9.2	Авлага.....	7
2.9.3	Урьдчилгаа	8
2.9.4	Бараа материал	8
2.9.5	Үндсэн хөрөнгө.....	8
2.9.6	Өр төлбөр.....	9
2.9.7	Засгийн газрын хувь оролцоо.....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12	Шилэн дансны мэдээлэл	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.14	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3.	Менежментийн захидал.....	12
3.1	Авлагын данстай холбоотой асуудал	12
3.2	Авлагын данстай холбоотой асуудал	12
3.3	Харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал	13
4.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.25 № 01/949
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гаалийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гаалийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.ТЭНГИС



2. Аудитын тайлан

2.1 Оршил

Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Асралт Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлага үүсгэхгүй байх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 10-наас 2020 оны 03 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Мөнхчимэг, Ч.Дашдаваа, гэрээт аудитор Ш.Ичинхорлоо нар гүйцэтгэв.

Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/731 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Гаалийн байгууллага нь үндэсний хөгжлийн зорилтод хувь нэмэр оруулах, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг нь гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл гаргах, гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудал болно.

Гаалийн ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гаалийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Гаалийн ерөнхий газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “ACOLOUS 3.0” программ хангамж ашигладаг байна.

Гаалийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гаалийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 79,264.9 сая төгрөгийн 2.0 хувь буюу 1,585.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 21 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 16 санхүүгийн тайлан аудитад хамрагдсан, 2 байгууллагад итгэл үзүүлж, 3 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 16 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 32,654.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 32,177.7 сая төгрөгийн 17 алдааг аудитын явцад залруулж, 95.3 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 171.4 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 210.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 31,752.2 сая төгрөгийг Сангийн яамны барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн боловч үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Техник хяналтын зардлын 80.3 сая төгрөгийн 2013-2017 онуудын үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

ГЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн төрийн сангийн харилцахад хөрөнгө оруулалтын барьцаа дансны 2008 оны үлдэгдэл 26.2 сая төгрөг, 2010 оны 8.2 сая төгрөг, 2011 оны 10.5 сая төгрөг, 2012 оны 21.5 сая төгрөг, 2013 оны 10.8 сая төгрөг, 2014 оны 11.4 сая төгрөг, нийт 88.6 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, олон жил дамжин бүртгэгдсэн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.3 "тогтсон хугацааны туршид гүйцэтгэх үүрэгтэй холбогдон шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

Төсвийн төвлөрүүлэн захирагчид 115.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 617.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 425.5 сая төгрөгийн 16 алдааг аудитын явцад залруулж, 2.5 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 95.3 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан

шаардлага хүргүүлж, 94.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 24 зөвлөмжийг хүргүүллээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 425.5 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Тайлант хугацаанд хөрөнгө худалдаж авсан 59.7 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан.
- Төсвөөс хөрөнгө худалдаж авсан 45.9 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалд тайлагнаагүй.
- Систем хоорондын тооцоогоор хуримтлагдсан элэгдлийн 46.2 сая төгрөгийг орлого бууруулах бичилт хийсэн.
- Тайлант оны түрээсийн төлбөрийн орлогоос хууль, журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төвлөрүүлсэн нийт 46.0 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэл тайланд тусгасан.

2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 837.5 сая, эцсийн үлдэгдэл 1,336.1 сая төгрөг болж, 498.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	0.1	0.5	0.4
Банканд байгаа бэлэн мөнгө	837.4	1,335.6	498.2
Дүн	837.5	1,336.1	498.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.5 сая төгрөг арилжааны банкны дансанд, 1,335.6 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 70.5 сая, эцсийн үлдэгдэл 860.6 сая төгрөг болж, 790.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.6	1.4	-0.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	12.8	15.0	2.2
Татаас, санхүүжилтийн авлага	0.8	0.4	-0.4
Байгууллагаас авах авлага	51.0	811.7	760.7
Хувь хүмүүсээс авах авлага	4.3	32.1	27.8
Дүн	70.5	860.6	790.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 38.3 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- 2013-2015 онуудад үүссэн Завхан аймаг дахь гаалийн хороо, хил хяналтын бусад байгууллагын гэрэл цахилгааны төлбөрийн 9.6 сая төгрөгийн авлага;
- 2009 оноос өмнө үүссэн нийт 26.1 сая төгрөгийн авлага нь харилцагч байгууллагуудын мэдээлэл Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Татварын ерөнхий газрын мэдээллийн санд байхгүй шийдвэрлэх боломжгүй болсон;
- Сэлэнгэ аймаг дахь гаалийн газарт 2000 оноос өмнө үүссэн орон сууцны ашиглалтын төлбөрийн 2.6 сая төгрөгийн шийдвэрлэх боломжгүй авлага байна.

Дээрх авлага нь цаашид барагдах найдваргүй болж үр дүнг бууруулах сөрөг үр дагавартай байна.

2.9.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 105.8 сая, эцсийн үлдэгдэл 24,480.9 сая төгрөг болж, 24,375.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	103.4	8,176.8	8,073.4
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	2.4	16,304.1	16,301.7
Дүн	105.8	24,480.9	24,375.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд 24,480.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой гарсан төлбөрүүд байна. Үүнд:

- Баянхошуу хилийн боомтод салбар лабораторийн барилга 658.1 сая төгрөг, Оюутолгой гаалийн хяналтын бүсэд салбар лабораторийн барилга 317.9 сая төгрөг, Шуурхай удирдлагын төв, Гаалийн төв лабораторийн барилга 15,300.0 сая төгрөг, ГЕГ, газар хороодын лабораторийн тоног төхөөрөмжийн урьдчилгаа 5,004.8 сая төгрөг, Гаалийн хяналт шалгалтад ашиглах" Телехяналт "-ын иж бүрдэл тоног төхөөрөмжийн урьдчилгаа 3,149.0 сая төгрөг нийт 24,430.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа;
- Автомашины даатгалын төлбөр 22.5 сая төгрөгийг улирлаар зардлыг тооцож бууруулах бичилт хийдэг байна.

2.9.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,668.9 сая, эцсийн үлдэгдэл 4,508.6 сая төгрөг болж, 2,839.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	47.8	53.7	5.8
Бэлэн бүтээгдэхүүн	203.5	537.7	334.3
Хангамжийн материал	1,315.8	3,820.5	2,504.7
Мал амьтад	101.8	96.7	-5.1
Дүн	1,668.9	4,508.6	2,839.7

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд харьяа гаалийн газар, хороодын албан хэрэгцээнд хуваарилахаар бэлтгэсэн хөрөнгө байна.

2.9.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 110,758.1 сая, эцсийн үлдэгдэл 86,943.2 сая төгрөг болж, 23,814.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	70,153.1	51,517.0	-18,636.0
Авто-тээврийн хэрэгсэл	1,957.0	1,571.2	-385.8
Машин тоног төхөөрөмж	33,053.4	28,054.8	-4,998.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	659.9	717.1	57.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7.2	7.2	-
Бусад үндсэн хөрөнгө	326.1	298.8	-27.2
Дуусаагүй барилга, байгууламж		204.8	204.8
Ном	37.4	37.4	-
Үндсэн хөрөнгийн дүн	106,194.1	82,408.3	-23,785.8

Программ хангамж	133.7	104.1	-29.5
Бусад биет бус хөрөнгө	4,430.3	4,430.8	0.3
Биет бус хөрөнгийн дүн	4,564.1	4,534.9	-29.2
Дүн	110,758.1	86,943.2	-23,814.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 567.5 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 10,381.9 сая, үнэ төлбөргүй болон бусад эх үүсвэрээр авсан 63.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 25,278.4 сая, акталсан 14,088.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

2.9.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 226.7 сая, эцсийн үлдэгдэл 472.3 сая төгрөг болж, 245.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажилчидтай холбогдсон өглөг	0.02	0.02	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3.06	2.76	-0.3
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	196.2	434.5	238.4
Бусад өглөг	27.4	35.0	7.6
Нийт дүн	226.7	472.3	245.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 434.5 сая төгрөгийн барьцаа, 2011 онд Нийслэлийн татварын газраас шалгалт хийж 2006-2010 онуудад НӨАТ төлөөгүй шалтгаанаар тавьсан 22.9 сая төгрөгийн актын төлбөр, 14.9 сая төгрөгийн бусад өглөгтэй байна.

2.9.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 113,214.3 сая, эцсийн үлдэгдэл 117,656.7 сая төгрөг болж, 4,442.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	70,229.4	70,229.3	-
Хуримтлагдсан үр дүн	36,877.5	41,320.0	4,442.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,107.4	6,107.4	-
Дүн	113,214.3	117,656.7	4,442.5

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.10 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 103,750.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 38,435.4 сая төгрөгийг урсгал зардалд, 65,15.2 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардал байна.

Нийт зардлын 102,297.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,453.4 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,585.5 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.1 хувиар биелүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого 132.1 сая төгрөгөөр давсан нь улсын хилээр нэвтэрч буй ачаа, эргэлтийн тоо эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор мэдүүлгийн маягтын үнэ, гаалийн

хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашигладаг нэг удаагийн ломбоны хураамжийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 98,673.2 сая төгрөг буюу 95.1 хувийн биелэлттэй оны эцэст урсгал зардлын санхүүжилтээс 3,823.8 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нийт 5,077.4 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь дараах голлох шалтгаантай байна. Үүнд урсгал үйл ажиллагааны зардлын хүрээнд:

- Хөшгийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтад ороогүй тул урсгал зардлын төсвөөс нийт 867.8 сая төгрөг зарцуулагдаагүй.
- Гаалийн шинэчлэлийн хүрээнд Сангийн яамнаас гаалийн байгууллагад 43 орон тоог нэмж шийдвэрлэсэн бөгөөд салбар лабораториудын барилгуудыг тайлант оны эцэст улсын комисст хүлээлгэн өгснөөс шалтгаалан дээрх орон тоогоор ажиллаагүй, үүнтэй холбоотой цалингийн зардал, байр ашиглалтын зардал гараагүй.

Мөн дээрх зардлуудаас гадна гаалийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд 1,371.4 сая төгрөгийн төсвийг хэмнэж ажилласан.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 65,315.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 65,052.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 247.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд, захиалагчийн хяналтын дансанд 358.9 сая төгрөгийг шилжүүлжээ.

Нэмэлт санхүүжилт: Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 30.0 сая төгрөг, туслах үйл ажиллагааны давсан орлогоос 345.4 сая төгрөг хуваарилагдсаныг ГЕГ-ын даргын А/240 тоот тушаалаар дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна.

- Багаж техник хэрэгсэл авах зардалд 189.2 сая төгрөг,
- Ахмадын үйл ажиллагаа дэмжихэд болон урамшуулал 230.0 сая төгрөг;
- Нэг удаагийн тэтгэмж 10 хүнд 20.0 сая төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 0.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Цаг хугацааны хязгаарлагдмал байдал, Төрийн нууцын болон Албаны нууцын тухай хуульд заасан зарим хязгаарлалтаас шалтгаалан, хэрэгжилтийг нь үнэлэх боломжгүй доорх асуудлыг дараагийн аудитад хамруулах, анхаарал татахуйц чухал асуудал гэж үзлээ. Үүнд:

- Өмнөх онуудад хураагдсан 1,979.2 сая төгрөгийн хөрөнгийг борлуулсан эсэхэд дахин хяналт хийх;
- Он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын санхүүжилт, техник хяналтын зардлын зарцуулалтыг хянах;
- Хөрөнгө бэлтгэхэд зориулж гэрээний дагуу олгосон урьдчилгаа 24,480.0 сая төгрөгийн зарцуулалт, хэрэгжилтийг хянах;
- Авлагын барагдуулалт, тендер шалгаруулалтаас шалтгаалж оны эцэст үүссэн 860.6 сая төгрөгийн авлагын талаар дараагийн аудитаар авч үзэх.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Гаалийн ерөнхий газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гаалийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гаалийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан нь төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлээгүй байна. Тухайлбал: 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр нормын хувцас авах 94.5 сая төгрөг шилжүүлэн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль, журам мөрдөгдөхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааг баталсан төлөвлөгөөнд заасан хугацаандаа зохион байгуулж авлага үүсгэхгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Авлагын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Томилолтын зардлын тооцоог тухай бүр хийгээгүйгээс авлагыг 21.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль, журам мөрдөгдөхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Томилолттой холбоотой тооцоог тухай бүр хийж, авлага үүсгэхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 617.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 425.5 сая төгрөгийн алдааг залруулж, 2.5 сая төгрөгийн зөрчилд 2 акт, 95.3 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 94.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 24 зөвлөмж өгсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,682,879.8	31,185,921.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	837,525.0	1,335,640.3
33	АВЛАГА	70,551.6	860,621.0
34	УРЬДЧИЛГАА	105,830.6	24,480,980.4
35	БАРАА МАТЕРИАЛ	1,668,972.7	4,508,679.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	110,758,105.0	86,943,208.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	110,758,105.0	86,943,208.9
39200	Биет хөрөнгө	106,194,022.1	82,408,327.6
39300	Биет бус хөрөнгө	4,564,082.9	4,534,881.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	113,440,984.9	118,129,130.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	226,675.0	472,338.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	226,675.0	472,338.2
41300	Өглөг	226,675.0	472,338.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	113,214,309.8	117,656,792.0
51	Засгийн газрын хувь оролцоо	113,214,309.8	117,656,792.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	70,229,324.4	70,229,324.4
51200	Хуримтлагдсан үр дүн	36,877,586.4	41,320,068.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,107,399.0	6,107,399.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	113,440,984.9	118,129,130.2

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	74,719,664.8	106,538,929.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,304,411.0	5,487,885.5
120	Нийтлэг татварын бус орлого	43,304,411.0	5,487,885.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,415,253.8	101,051,043.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	45,130,273.3	79,264,939.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,288,087.5	79,264,939.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,715,245.6	42,945,089.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,458,388.6	22,099,018.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,335,356.7	2,778,997.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,072,065.2	2,279,061.2
2104	Хангамж, бараа материалын зардал	607,208.9	709,131.0
2105	Нормативт зардал	295,191.3	156,260.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	592,574.0	724,804.6
2107	Томилолт, зочны зардал	118,508.0	117,382.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,708,269.5	1,743,100.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,527,683.4	12,337,333.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,572,841.9	36,319,849.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,842,185.8	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	29,589,391.6	27,273,990.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	38,394,548.1	22,839,052.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-8,805,156.6	4,434,937.1

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	33,772,156.4	103,645,649.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,356,142.4	2,594,039.8
120	Нийтлэг татварын бус орлого	2,356,142.4	2,594,039.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	31,416,014.1	101,051,609.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,561,572.8	37,357,717.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,561,572.8	37,357,717.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,883,325.8	32,809,553.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,441,900.7	22,026,445.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,345,013.2	2,760,847.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,053,741.8	2,300,672.9
2104	Хангамж, бараа материалын зардал	445,998.3	583,385.0
2105	Нормативт зардал	133,461.3	1,186,386.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	859,389.5	1,078,619.0
2107	Томилолт, зочны зардал	118,638.5	138,179.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,967,451.6	1,960,336.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	517,731.0	774,681.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,678,247.0	4,548,164.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,210,583.6	66,287,931.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,227,544.2	65,789,816.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,227,544.2	65,789,816.2
2200	Дотоод эх үүсвэрээр	2,227,544.2	65,789,816.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,227,544.2	-65,789,816.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-16,960.6	498,115.3
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	854,485.6	837,525.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	837,525.0	1,335,640.3

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,814,721.1	0	124,814,721.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,248,004.1	0	-9,248,004.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	115,566,717.0	0	115,566,717.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	2,022,331.9	0	2,022,331.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,430,417.5	0	4,430,417.5
6	Тайлант үеийн үр дүн	-8,805,156.6	0	-8,805,156.6
7	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,214,309.8	0	113,214,309.8
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,545.0	0	7,545.0
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,221,854.9	0	113,221,854.9
10	Тайлант үеийн үр дүн	4,434,937.1	0	4,434,937.1
11	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,656,792.0	0	117,656,792.0

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,750,622.0	98,673,206.2	5,077,415.7	95.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,435,422.0	33,620,856.2	4,814,565.7	87.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,751,235.8	33,219,213.4	4,532,022.3	88.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,885,905.3	22,026,445.6	1,859,459.6	92.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,890,085.8	2,760,847.3	129,238.4	95.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,885,426.2	2,300,167.6	585,258.5	79.7
2104	Хангамж, бараа материалын зардал	661,498.7	584,794.6	76,704.0	88.4
2105	Нормативт зардал	1,188,210.3	1,186,385.9	1,824.3	99.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,889,342.5	1,548,643.6	340,698.8	82.0
2107	Томилолт, зочны зардал	164,729.2	138,179.1	26,550.0	83.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,685,258.0	1,997,043.9	688,214.0	74.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,779.8	676,705.3	824,074.4	45.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	684,186.2	401,642.8	282,543.3	58.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	76,482.2	74,679.1	1,803.0	97.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	607,704.0	326,963.7	280,740.2	53.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,315,200.0	65,052,349.9	262,850.0	99.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	103,750,622.0	98,673,001.5	5,077,620.4	95.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	102,297,134.8	97,087,507.4	5,209,627.3	94.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,453,487.2	1,585,494.0	-132,006.8	109.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,603	1,440	163	89.8
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,603	1,440	163	89.8

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	485,629.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	315,729.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,806.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	505.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,301.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,542.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,458.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	265,923.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,923.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	169,900.0
2200	Дотоод эх үүсвэрээр	169,900.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	485,629.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	485,629.9

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2019 он			САГ-2020/02/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын	Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Тайлант оны эцэст худалдан авах ажиллагаа зохион байгуулсан нь төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.	94.5	Зөвлөмж	Гаалийн улсын ахлах байцаагч	Д.Алтанчимэг
2	Томилолтын зардлын тооцоог тухай бүр хийгээгүйгээс авлагыг 21.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.	21.3	Зөвлөмж	Гаалийн улсын ахлах байцаагч	А.Болор-Эрдэнэ
3	Техник хяналтын зардлын 80.3 сая төгрөгийн 2013-2017 онуудын үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй.	80.3	Төлбөрийн акт	Гаалийн улсын ахлах байцаагч	А.Болор-Эрдэнэ
4	ГЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн төрийн сангийн харилцахад хөрөнгө оруулалтын барьцаа дансны 2008 оны үлдэгдэл 26.2 сая төгрөг, 2010 оны 8.2 сая төгрөг, 2011 оны 10.5 сая төгрөг, 2012 оны 21.5 сая төгрөг, 2013 оны 10.8 сая төгрөг, 2014 оны 11.4 сая төгрөг, нийт 88.6 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, олон жил дамжин бүртгэгдсэн өглөгийн үлдэгдэлтэй байна.	88.6	Төлбөрийн акт	Гаалийн улсын ахлах байцаагч	Д.Алтанчимэг
5	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 617.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 425.5 сая төгрөгийн алдааг залруулж, 2.5 сая төгрөгийн зөрчилд 2 акт, 95.3 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 94.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 24 зөвлөмж өглөө.	192.2	Харьяа газруудад илэрсэн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх, талаар анхаарч ажиллах зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагчид	Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газрын дарга нар
	Дүн	476.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/79

Улаанбаатар хот

СНГ-2020/02/СТА-ТТЗ

Орлого төвлөрүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан цаглабарт хугацаанд Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Техник хяналтын зардлын 80.3 сая төгрөгийн 2013-2017 онуудын үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Техник хяналтын дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 80.3 сая төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх.
2. Биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Үйлчилгээ, аж ахуйн албаны дарга Ц.Отгонжаргал, гаалийн улсын ахлах байцаагч А.Болор-Эрдэнэ нарт даалгав.

АКТЫГ:

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР Г.МӨНХЧИМЭГ
АУДИТОР Ч.ДАШДАВАА



ЗӨВШӨӨРСӨН:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.АСРАЛТ
САНХҮҮ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ДОЛГОРСҮРЭН
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ А.БОЛОР-ЭРДЭНЭ

Акт, албан шаардлага, биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Akt\2020\0325\ACT Docx

001090227



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/81

Улаанбаатар хот

САГ-2020/02/СТА-ТТЗ

Орлого төвлөрүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан цаглабарт хугацаанд Гаалийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ГЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн төрийн сангийн харилцахад хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 2008 оны үлдэгдэл 26.2 сая төгрөг, 2010 оны 8.2 сая төгрөг, 2011 оны 10.5 сая төгрөг, 2012 оны 21.5 сая төгрөг, 2013 оны 10.8 сая төгрөг, 2014 оны 11.4 сая төгрөг, нийт 88.6 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, олон жил дамжин бүртгэгдсэн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.3 "тогтсон хугацааны туршид гүйцэтгэх үүрэгтэй холбогдон шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа гурван жил", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 88.6 сая төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх.
2. Биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Долгорсүрэн, гаалийн улсын ахлах байцаагч Д.Алтанчимэг нарт даалгав.

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР Г.МӨНХЧИМЭГ
АУДИТОР Ч.ДАШДАВАА

9000109
9019120396

АКТЫГ:

ЗӨВШӨӨРСӨН:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Б.АСРАЛТ
САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
Д.ДОЛГОРСҮРЭН
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
Д.АЛТАНЧИМЭГ

Акт, албан шаардлага, биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Akt\2020\0325SAG3.Docx

001090730

